

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2022 ОНЫ НЭГТГЭСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:

ДУА-2023/01/НА-СТА-ТЕЗ

Дундговь дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Аудитын менежер Х.Наранцацрал

Аудитор Ж.Угтахбаяр

Аудитор Т.Оюун-Эрдэнэ

Утас: 7059-3113

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 20, өдөр

Дугаар 4/09

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан”-д хийсэн аудитын тайлан / ДУА-2023/1/НА-СТА-ТЕЗ/-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага)-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2023 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, Татварын хэлтсийн дарга /М.Туяацэцэг/ нарт зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор /Д.Ихбаяр/, аудитор /Т.Оюун-Эрдэнэ/, аудитор /Ж.Угтахбаяр/ нарт үүрэг болгосугай.

Р.МӨНХТОГТОХ



Тайланг бэлтгэсэн:	<i>Товчилсон үгс</i>	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</i>	5
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Орлогыг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлээс 8 нэр төрлийн орлогыг бууруулж баталсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан төлөвлөөгүй байна.	6-9
Аудитор: Ж.Угтахбаяр Т.Оюун-Эрдэнэ	1.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт 3,490.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.	9-14
	2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7059-3113 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Орон нутгийн сан”-гийн журмыг бүртгээгүй байхад 1,000.0 сая төгрөгийг зарцуулахаар төсөв баталсан нь урсгал зардлыг бодит тооцоололд үндэслэн төлөвлөөгүй байна.	14-19
	2.2 Төсвийн гүйцэтгэл 80.6 хувьтай, яамдтай байгуулсан гэрээ 92.9 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн нь төсвийн үр ашиг хангалттай байгааг харуулж байна.	19-23
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 210 тоот	2.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 288.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.	24-25
2023 оны 4 дүгээр сар	2.4 Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.	26-28
	Дүгнэлт	29
	Зөвлөмж	30-31
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, аудитын газрын тайлбар	32-33
	Хавсралт	34-37



ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНТБ	Орон нутгийн төсвийн байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УОО	Урьдчилж орсон орлого
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалган, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай зарцуулсан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн зохицуулалт хийсэн судалгаа, мэдээлэл болон татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Татварын багц хуулиуд;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг



хэрэгжүүлж, аудитор Ж.Угтахбаяр, Т.Оюун-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ 40,864.9 САЯ ТӨГРӨГӨӨР ТӨЛӨВЛӨЖ 108.5 ХУВИАР БУЮУ 3,490.8 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛЖЭЭ.

1.1 Орлогыг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлээс 8 нэр төрлийн орлогыг бууруулж баталсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан төлөвлөөгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг баталжээ. Тус хуулийн 14 дүгээр зүйлд Дундговь аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 11,936.1 сая, 16 дугаар зүйлд ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 7,875.3 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль болон аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвийн нийт орлогыг 40,864.9 сая төгрөгөөр баталсныг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №1 /сая төгрөгөөр/

№	Орлогын эх үүсвэр	2021 оны төлөвлөгөө		Нийт	2022 оны төлөвлөгөө		Нийт	Зөрүү
		Аймаг	Сум		Аймаг	Сум		
	А	1	2	3	4	5	6	7=6-3
1	Санхүүгийн дэмжлэг	10,942.1	-	10,942.1	11,936.1	-	11,936.1	994.0
2	ОНХС	6,694.7	-	6,694.7	7,875.3	-	7,875.3	1,180.6
3	Татварын орлого	5,605.8	2,505.0	8,110.8	1,226.0	8,307.0	9,533.0	1,422.2
4	Урьд оны үлдэгдэл	2,281.3	3,262.7	5,544.0	1,782.5	5,096.5	6,879.0	1,335.0
5	ОНЕО үлдэгдлээс	1,221.6	959.6	2,181.2	1,403.0	1,292.7	2,695.7	514.5
6	Төвлөрүүлэх орлого	268.9	1,899.7	2,168.6	287.3	1,658.4	1,945.7	(222.9)
7	Эрүүл мэндийн даатгал	409.2		409.2			-	(409.2)
	Дүн	27,014.4	8,627.0	35,641.4	24,510.2	16,354.6	40,864.9	5,223.5

Өмнөх онтой харьцуулахад санхүүгийн дэмжлэг 994.0 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 1,180.6 сая төгрөгөөр өссөн байна.

Дундговь аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх¹ хэсэгт заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийг өргөн мэдүүлж, орон нутгийн төсвийн орлогыг батлуулжээ.

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор 2022 оны орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 27,653.7 сая

¹ Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 /Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ/



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

төгрөгөөр баталсныг 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 26,832.3 сая төгрөг болгон 821.4 сая төгрөгөөр бууруулан тодотгож баталсан байна.

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/

Эх үүсвэр		2021 оны төлөвлөгөө	2022 он		
		1	төлөвлөгөө 2	тодотгосон 3	зөрүү 4=3-2
Улсын төсвөөс	ТЗШ	28,214.9			-
	ОНХС	6,694.7	8,457.2	7,875.3	(581.9)
	ЭМД-ын сангаас	409.2			-
Орон нутгийн төсвөөс	Санхүүгийн дэмжлэг	10,942.1	14,610.3	11,936.1	(2,674.2)
	Татварын болон татварын бус орлого	5,605.8	1,482.6	1,226.0	(256.6)
	ОНЕО-ын үлдэгдэл	1,221.6	624.4	1,403.0	778.6
	Төвлөрүүлэх орлого	216.7	781.5	2,608.4	1,826.9
	Урьд оны үлдэгдэл	2,333.6	1,697.7	1,783.5	85.8
дүн		55,638.6	27,653.7	26,832.3	(821.4)

Тус тодотгол хийсэн тогтоолоор нийт орлогын төлөвлөгөөг бууруулж баталсан ч төвлөрүүлэх орлогыг 3.3 дахин, орон нутгийн ерөнхий орлогын урьд оны үлдэгдлийг 2.2 дахин нэмэгдүүлсэн байна.

Төвлөрүүлэх орлого өссөн нь дараах шалтгаануудтай байна.

- Орон нутгийн санг шинээр хандив, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр 1,000.0 сая төгрөгийн төлөвлөгөөг нэмж баталсан,
- Татварын шинэчлэлтэй холбоотой Сайнцагаан сум аймгийн төсөвт 1,481.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг дагаж батлагдсан Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогыг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлэхтэй холбоотой хуулийн хэрэгжилттэй холбоотой Сайнцагаан сумын зардлаас давсан орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01 ний өдрийн А/464 тоот захирамжаар зохицуулалт хийж, 1,000.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг бууруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 оны төсвийн төслийг удирдамжид заасан зарчмын хүрээнд орон нутгийн төсвийн суурь орлогыг 21 нэр төрлөөр нийт 6,874.1 сая төгрөгөөр боловсруулж, тус хуулийн 8.4.3²-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлжээ. Сангийн яам 2022 оны төсвийн жилийн суурь орлогыг 1,474.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 8,349.0 сая төгрөг болгон хянасан байна.

Орон нутгаас хүргүүлсэн орлогын төсвийн төслийг Сангийн яамны хянасан дүнтэй зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

² “Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”



Хүснэгт №3 /сая төгрөгөөр

№	Орлогын төрөл	Сангийн яаманд хүргүүлсэн санал	Сангийн яамны хянасан	Батлагдсан	/Нэмэгдсэн +, хасагдсан -/
	А	1	2	3	4=3-2
1	Татварын орлого	5,595.2	6,645.0	7,996.3	1,351.3
2	Татварын бус орлого	1,247.9	1,674.0	1,506.7	-167.3
3	Хөрөнгийн орлого	31.0	30.0	30.0	0.0
	Нийт орлогын дүн	6,874.1	8,349.0	9,533.0	1,184.0

Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн саналаас аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 470.0 сая, хүүгийн орлогыг 66.7 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 167.3 сая төгрөгөөр нэмж хянасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрээр Сангийн яамны хянасан орлогоос 4 нэр төрлийн орлогыг 0.3-167.3 сая төгрөгөөр бууруулж, 7 нэр төрлийн орлогыг 0.3-1,210.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 9,533.0 сая төгрөг болгон баталсан байна. Хасаж баталсан орлогыг нэр төрлөөр нь авч үзэхэд:

- Үйл ажиллагааны орлогыг 3.5 сая;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 95.3 сая;
- Бууны албан татварыг 0.3 сая;
- Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 167.3 сая төгрөгөөр тус тус хасаж баталжээ.

1.1.1. Татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс 353.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Орон нутгийн орлогын 83.9 хувь нь татварын орлогоос, 15.8 хувь нь татварын бус орлогоос, 0.3 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

Хүснэгт №4 //сая төгрөгөөр/

№	Татварын бус орлогын төрөл	2020 он		2021 он		2022 оны төлөв лөгөө	Өөрчлөлт	
		Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Төлөв лөгөө	Гүйцэт гэл		6=5-3	7=5-4
	А	1	2	3	4	5	6	7
1	Хадгаламжийн хүүгийн орлого	751.9	777.3	629.9	893.2	866.7	236.8	(26.5)
2	Торгуулийн орлого	451.6	550.1	444.0	680.4	550.0	106.0	(130.4)
3	Бусад орлого	49.9	113.9	450.2	276.1	80.0	(370.2)	(196.1)
4	Түрээсийн орлого					10.0	10.0	-
	Дүн	1,253.4	1,441.3	1,524.1	1,849.6	1,506.7	(17.4)	(353.0)

Үүнээс үзэхэд өмнөх оны орлогын төлөвлөгөө төрөл бүрээр давж биелсэн байхад тайлант оны торгуулийн орлого, хадгаламжийн хүүгийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс бууруулан баталжээ. Харин төсвийн байгууллагын зарим нийтлэг ажил, үйлчилгээг аж ахуйн тооцооны үндсэн дээр төрийн болон орон нутгийн өмчит компани, хувийн хэвшлээр гүйцэтгүүлснээр төрийн өмчөөр түрээсийн орлогыг төвлөрүүлнэ гэж төлөвлөсөн байна.



1.1.2 Татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөнөөс 1,444.6 сая төгрөгөөр, өмнөх оны гүйцэтгэлээс 202.6 сая төгрөгөөр тус тус нэмж баталсан байна.

Хүснэгт №5 /сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл А	2021 он		2022 оны төлөвлөгөө	Өөрчлөлт	
		Төлөвлөгөө 1	Гүйцэтгэл 2		5=3-1 5	6=3-2 6
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	4,200.0	4,466.4	4,400.0	200.0	(66.4)
2	Үйл ажиллагааны орлого	497.3	419.3	596.5	99.2	177.2
3	Хөрөнгө борлуулсны орлого /2 хувь/	64.2	135.0	60.0	(4.2)	(75.0)
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(283.1)	(283.1)	(361.3)	(78.2)	(78.2)
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар			374.7	374.7	374.7
6	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	170.0	166.5	190.0	20.0	23.5
7	Бууны албан татвар	19.5	18.9	24.7	5.2	5.8
8	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	300.0	303.6	320.0	20.0	16.4
9	Малд ногдуулах албан татвар	600.4	695.0	1,210.5	610.1	515.5
10	Улсын тэмдэгтийн хураамж	185.0	138.1	190.0	5.0	51.9
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	28.5	7.4	20.3	(8.2)	12.9
12	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	149.6	174.3	170.2	20.6	(4.2)
13	Бусад албан татвар	56.9	50.5	50.0	(6.9)	(0.5)
14	Газрын төлбөр	286.1	402.2	362.0	75.9	(40.2)
15	Дуудлага худалдаа	50.0	203.0	88.0	38.0	(115.0)
16	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	167.3	644.2	200.0	32.7	(444.2)
17	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	60.0	252.4	100.0	40.0	(152.4)
18	Нохойны албан татвар			0.8	0.8	0.8
	Татварын орлогын дүн	6,551.7	7,793.7	7,996.3	1,444.6	202.6

Хүснэгтээс татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзвэл өмнөх онд 8 төрлийн орлого 1,303.9 сая төгрөгөөр давж биелсэн байхад тайлант оны орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс 897.9 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Өмнөх оны гүйцэтгэлээс бууруулан баталсан орлогын төлөвлөгөөнүүдээс дараах орлогууд байна. Үүнд:

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 66.4 сая;
- Хөрөнгө борлуулсны орлогыг 75.0 сая;
- Газрын төлбөрийг 40.2 сая;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 444.2 сая;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 152.4 сая төгрөгөөр тус тус бууруулжээ.

1.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт 3,490.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 40,864.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 44,355.7 сая төгрөгийг төвлөрүүлэн, 3,490.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Төсвийн орлогын эх үүсвэрийг орлогын нэр төрлөөр харууллаа.

Хүснэгт №6 /сая төгрөгөөр/



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орлогын эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Аймаг			
Санхүүгийн дэмжлэг	11,936.1	11,936.1	-
ОНХС	7,875.3	7,875.3	-
Татварын орлого	1,226.0	1,844.6	618.6
Урьд оны үлдэгдэл	1,782.5	2,425.4	642.9
ОНЕО үлдэгдлээс	1,403.0	1,974.1	571.1
Төвлөрүүлэх орлого	287.3	605.0	317.7
Дүн	24,510.2	26,660.7	2,150.4
Сум			
Татварын орлого	8,307.0	9,027.8	720.7
Урьд оны үлдэгдэл	5,096.5	5,404.7	308.2
ОНЕО үлдэгдлээс	1,292.7	1,434.0	141.2
Төвлөрүүлэх орлого	1,658.4	1,828.6	170.2
Дүн	16,354.6	17,695.0	1,340.4
Нийт дүн	40,864.9	44,355.7	3,490.8

1.2.1 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн авчээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын төсвөөс 11,936.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 7,785.3 сая төгрөгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг бүрэн авчээ.

1.2.2 Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 114.4 хувьтай биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус 9,533.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 10,872.4 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 1,339.4 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын орлого 1,945.7 сая төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 1,401.7 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 1,031.9 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 487.9 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орлогын төлөвлөгөөг 12 сум 2.7-47.1 хувиар давуулан биелүүлж, 3 сум 0.3-2.9 хувиар тасалсан байна. Үүнийг сум тус бүрээр харуулбал:

Хүснэгт №8 /сая төгрөгөөр/					
№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан/тасарсан	
				Зөрүү	Хувь
1	Дэлгэрцогт	203.8	230.0	26.2	112.9
2	Дэрэн	279.5	411.1	131.6	147.1
3	Говь-Угтаал	297.1	408.3	111.2	137.4
4	Цагаандэлгэр	140.8	173.1	32.3	122.9
5	Баянжаргалан	296.6	309.8	13.2	104.5
6	Өндөршил	294.4	339.2	44.8	115.2
7	Гурвансайхан	454.5	450.4	(4.1)	99.1
8	Өлзийт	345.4	429.5	84.1	124.3
9	Хулд	243.5	287.6	44.1	118.1
10	Луус	244.5	243.8	(0.7)	99.7
11	Дэлгэрхангай	276.9	290.3	13.3	104.8
12	Сайхан-Овоо	206.1	200.2	(5.9)	97.1
13	Эрдэнэдалай	573.3	588.9	15.6	102.7
14	Сайнцагаан	4,208.7	4,397.8	189.0	104.5
15	Адаацаг	241.9	267.9	26.0	110.8
16	Мандалговь	1,226.0	1,844.7	618.7	150.5
Нийт дүн		9,533.0	10,872.5	1,339.5	

Орлогын төлөвлөгөөг өндрөөр биелүүлсэн Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумын шалтгааныг тодруулахад төлөвлөгөө батлаагүй ан амьтны нөөц ашигласны төлбөр 77.8



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

сая, хөрөнгө борлуулсны орлого 5.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Татварын орлогын гүйцэтгэл

Татварын орлогыг нэр төрлөөр нь төлөвлөгөө, гүйцэтгэлээр нь харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 7 /сая төгрөгөөр/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	4,400.0	5,110.5	710.5
2	Үйл ажиллагааны орлого	596.5	418.1	(178.4)
3	Хөрөнгө борлуулсны орлого /2 хувь/	60.0	123.4	63.4
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(361.3)	(361.3)	0.0
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	374.7	376.0	1.3
6	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	190.0	170.3	(19.7)
7	Бууны албан татвар	24.7	16.4	(8.3)
8	Автотээврийн болон өсрөө явагч хэрэгслийн албан татвар	320.0	333.0	13.0
9	Малд ногдуулах албан татвар	1,210.5	1,018.3	(192.2)
10	Улсын тэмдэгтийн хураамж	190.0	140.6	(49.4)
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.3	10.6	(9.7)
12	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	170.2	171.8	1.7
13	Бусад албан татвар	50.0	55.5	5.5
14	Газрын төлбөр	362.0	537.7	175.7
15	Дуудлага худалдаа	88.0	155.3	67.3
16	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	200.0	650.6	450.6
17	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	100.0	403.1	303.1
18	Нохойны албан татвар	0.8	-	(0.8)
	Татварын орлогын дүн	7,996.3	9,330.0	1,333.7

Татварын орлогын төлөвлөгөө нийт 1,333.7 сая төгрөгөөр давж биелсэн нь дараах 4 нэр төрлийн орлоготой холбоотой байна. Тодруулбал:

- **Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого төлөвлөгөөнөөс 1.2 дахин давж биелжээ.**

Тус орлогыг 4,400.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,110.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь Монгол Улсын Засгийн газраас төрийн байгууллагын зарим албан хаагчдын албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотой байна.

- **Газрын төлбөрийн орлого 1.5 дахин давж биелсэн.**

Тайлант онд 362.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 537.7 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Орлогын төлөвлөгөө давж биелсэн нь газрын төлбөрийн ногдуулалтыг цахимаар үүсгэдэг болсноос шалтгаалж өссөн байна.

- **Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 4.0 дахин давж биелсэн.**

Ус рашааны нөөц ашигласны төлбөрийг 100.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 403.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь “Эрдэнэс силвер ресурс” ХХК-



ийн баяжуулах үйлдвэр ашиглалтад орж 377.0 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

➤ **Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 3.3 дахин давж биелсэн.**

Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 650.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь орлогын төлөвлөгөө батлагдаагүй Говь-Угтаал, Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Сайнцагаан сумд нийт 231.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Харин Дэрэн, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт сумд төлөвлөгөөг 2.5 дахин давуулан биелүүлжээ. Төлөвлөгөө давсан шалтгаан нь БОАЖЯ-аас ангийн зөвшөөрлийн төлөвлөгөөг төсөв батлагдсанаас хойш ирүүлдэг, идлэг шонхор шувууг барих төлөвлөгөөнд өөрчлөлт ордогтой тус тус холбоотой байна.

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн ч 4 нэр төрлийн орлого тасарсан байна.

- **Үйл ажиллагааны орлогын** төлөвлөгөө нийт дүнгээр 178.4 сая төгрөгөөр тасарсан байна. Баянжаргалан, Гурвансайхан, Дэрэн сумд 36.0-90.3 хувиар тус тус тасалсан нь арьс шир, ноосны урамшууллын орлого буурсан байна.
- **Малын тоо толгойн албан татвар** нийт дүнгээрээ 192.2 сая төгрөгөөр тасарсан нь малчдын малын татвар төлөх мэдээлэл хомс, отор нүүдэл их, татварын байцаагчийн хүрэлцээ муу байна.
- **Улсын тэмдэгтийн хураамж** нийт дүнгээрээ 49.4 сая төгрөгөөр тасарсан нь Цагаандэлгэр, Луус, Дэлгэрхангай, Хулд, Адаацаг сумд 36.6-86.1 хувиар тус тус тасалсан нь нөлөөлжээ. Тайлант онд зарим сумдад нотариатын үйлчилгээ эрхлэх эрх бүхий албан тушаалтан байхгүй, аж ахуйн нэгж, байгууллагуудын архи, тамхины тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүйгээс эрх сунгалт бага байсантай холбоотой байна.
- **Үл хөдлөх эд хөрөнгийн татвар** нийт дүнгээрээ 19.7 сая төгрөгөөр тасарсан нь орлогын төлөвлөгөөг өмнөх жилүүдийн төлөвлөгөө, гүйцэтгэлээс өндрөөр баталсантай холбоотой байна.

Татварын бус орлогын гүйцэтгэл

Тайлант хугацаанд 1,536.7 сая төгрөгийн татварын бус орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,542.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөө 5.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №9 /сая төгрөгөөр/

№	Татварын бус орлогын төрөл	2022 он		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	А	1	2	3=2-1
1	Хадгаламжийн хүүгийн орлого	866.7	636.4	(230.3)
2	Торгуулийн орлого	550.0	765.0	215.0
3	Бусад орлого	80.0	41.7	(38.3)
4	Түрээсийн орлого	10.0	50.7	40.7
5	Хөрөнгийн орлого	30.0	48.7	18.7
	Дүн	1,536.7	1,542.5	5.8



- Хадгаламжийн хүүгийн орлого 230.3 сая төгрөгөөр тасарсан нь хадгаламжийн хүү буурч, арилжааны банкин дахь иргэдийн хадгаламж буурсантай холбоотой байна.
- Бусад орлого 38.3 сая төгрөгөөр тасарсан нь Дэрэн, Говь-Угтаал, Баянжаргалан, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус, Эрдэнэдалай сумд нийт 17.8 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч огт орлого төвлөрүүлээгүй байна.

1.2.3 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг 374.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 72.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг 500.0 сая төгрөгөөр төлөвлөснийг гүйцэтгэлээр 490.0 сая төгрөгийг төвлөрүүлж, 10.0 сая төгрөгийн орлогыг тасалсан байна. Орлогын төлөвлөгөөнд 2022 оны татварын ногдуулалтаас гадна өмнөх онуудын татварын өрийг барагдуулахаар төлөвлөжээ.

Сангийн сайдын 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам"-ын 3.5³-т заасны дагуу улсын төсөвт төвлөрүүлсэн орлогоос 40 хувийг орон нутгийн төсөвт хуваарилдаг болжээ. Тайлангаас харахад орон нутгийн төсвийн орлогыг батлахдаа ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг 374.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 376.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зөрүү
		Тайлант орлого	УОО	
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	374.7	72.7	303.3	1.3
Дүн	374.7	72.7	303.3	

Гүйцэтгэлийг авч үзэхэд тус журмын дагуу Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж, татвар төлсөн аж ахуйн нэгжийн татварын орлогоос орон нутгийн төсөвт нийт 72.7 сая төгрөгийг хуваарилсан нь тайлант оны орлогын бодит гүйцэтгэл бөгөөд орлогын төлөвлөгөө 302.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Сангийн яам 10 аймгийн хүсэлт, орлогын биелэлт, нөхцөл байдлыг харгалзан үзэж 2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос урьдчилан олгожээ. Сангийн яаманд аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01/1752 дугаар албан бичгээр явуулсан хүсэлтийн дагуу Татварын ерөнхий газраас 303.3 сая төгрөгийг аймгийн Төрийн сангийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын /1000800000203/ дансанд олгожээ. Дээрх шилжүүлгийг Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу санхүүгийн тайланд урьдчилж орсон орлогоор бүртгэсэн боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогыг хүлээн зөвшөөрч тайлагнасан зөрчил илэрлээ.

³ /Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг төсвийн тогтворжуулалтын санд хуваарилж тэнцвэржүүлэн тооцсон орлогоос аймаг, нийслэлийн төсөвт хуваарилна/



Энэ нь тайлант онд хамааралгүй, 2023 оны орлогоос урьдчилж орсон орлогыг татварын орлогын гүйцэтгэлээр тайлагнаж, тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэлтэй байна.

Иймд аж ахуйн нэгжийн татварын орлогын төлөвлөгөөг орон нутгийн татварын баазад тулгуурлан бодитой төлөвлөх, нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, олон улсын стандартын дагуу бүртгэх шаардлагатай байна.

2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ТӨСВИЙГ ХЭМНЭЛТГҮЙ ЗАРЦУУЛСАН ЗӨРЧЛҮҮД ИЛЭРЧЭЭ.

2.1 Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Орон нутгийн сан”-гийн журмыг бүртгээгүй байхад 1,000.0 сая төгрөгийг зарцуулахаар төсөв баталсан нь урсгал зардлыг бодит тооцоололд үндэслэн төлөвлөөгүй байна.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас ирүүлсэн Орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжийн хүрээнд 2022 оны орон нутгийн төсвийн төслийг нийт 25,119.7 сая төгрөгөөр боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.4.3⁴ дахь заалтад заасны дагуу Сангийн яаманд хүргүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг Сангийн яам 8.8 хувь буюу 2,210.3 сая төгрөгөөр бууруулж, 22,909.4 сая төгрөгөөр хянасан байна.

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор орон нутгийн 2022 оны төсвийн эх үүсвэр болон зарлагыг 27,653.7 сая төгрөгөөр баталсныг 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 821.4 сая төгрөгөөр хасах тодотгол хийсэн байна.

Орон нутгийн төсвийг баталсан, тодотгол хийсэн тогтоолуудыг хүснэгтээр харууллаа.

Зарцуулах эрх	Өмнөх он	Тайлант он		Зөрүү	
		2022.12.03 №21	2023.05.26 №27	Өмнөх оноос	Анхны батлагдсан
ОНТБ	11,232.6	15,390.3	16,328.9	5,096.2	938.5
ОНХС /сумд/	2,170.8	4,242.9	3,952.0	1,781.2	-290.9
Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	9,553.8	8,020.5	6,551.5	-3,002.2	-1,469.0
ТЗШБ	28,929.0	0.0	0.0	-28,929.0	0.0
Нийт дүн	51,886.2	27,653.7	26,832.3	-25,053.8	-821.4

Тодотгосон төсвийг өмнөх онтой харьцуулахад 25,053.8 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нийтлэг үйлчилгээний ажилчдын цалин, байр ашиглалттай холбоотой зардлаас бусад зардлыг холбогдох яамд санхүүжилтийг олгодог болсонтой холбоотой байна. /Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх

⁴ Төсвийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.4.3⁴ дахь хэсэг /Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх/

боловсрол, Эрүүл мэндийн төв, соёлын байгууллагууд/


Орон нутгийн төсөвт тодотгол хийж анхны батлагдсан төсвийг бууруулан баталсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг 2,674.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 581.9 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан;
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нийтлэг үйлчилгээний ажилчдын цалинг улсын төсвөөс олгох болсонтой тус тус холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсвийн нийт зардлын төлөвлөгөөг 40,864.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Сүүлийн 5 жилийн орон нутгийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад 2018 оноос 2021 онд өсөж, 2022 онд буурчээ.



Тайлант онд төсвийн нийт зарлага 40,864.9 сая төгрөгийг дараах зардлуудад зарцуулахаар төлөвлөжээ. Үүнд:



Төсвийн гүйцэтгэлийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн хавсралт 1-т харуулав.

Нийт зардлын 52.5 хувийг бараа, ажил үйлчилгээний зардалд, 2.7 хувийг татаас, урсгал шилжүүлэгт, 38.0 хувийг хөрөнгийн зардалд, 6.8 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг тайлант оны болон өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №12 /сая төгрөгөөр/




ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэлээс	Тайлант оны гүйцэтгэлээс
Бараа, ажил үйлчилгээний зардал	45,907.7	21,452.8	19,730.5	(24,454.9)	1,722.32
Татаас ба урсгал шилжүүлэг	1,824.9	1,091.1	1,013.9	(733.8)	77.18
Хөрөнгийн зардал	7,803.6	15,535.5	11,103.4	7,731.9	4,432.10
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	851.6	2,785.5	1,109.3	1,933.9	1,676.15
Нийт дүн	56,387.8	40,864.9	32,957.1	-15,523.0	7,907.7

Тайлант оны төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардлыг 24,454.9 сая, татаас ба урсгал шилжүүлгийг 733.8 сая төгрөгөөр бууруулан, хөрөнгийн зардлыг 7,731.9 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийг 1,933.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 15,523.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна. Энэ нь улсын төсвийн байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг зардлын бүлгээр өмнөх онтой харьцуулан графикаар харууллаа.



Графикаас харахад өмнөх оноос бараа, ажил үйлчилгээний зардал 26,549.4 сая, татаас ба урсгал шилжүүлэг 779.8 сая төгрөгөөр тус тус буурсан байхад хөрөнгийн зардал 3,289.9 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл 639.0 сая төгрөгөөр өссөн байна.

2.1.1 “Орон нутгийн сан”-г байгуулах зөвшөөрөл ирээгүй байхад 1,000.0 сая төгрөгийг зарцуулахаар төсөв баталсан нь урсгал зардлыг бодит тооцоололд үндэслэн төлөвлөөгүй байна.

Төсвийн урсгал зардлыг 25,188.7 сая төгрөгөөр бууруулан /хүснэгт №12/ тодотгосон ч орон нутгийн төсвийн байгууллагуудын зардлыг 938.5 сая төгрөгөөр нэмж баталсан нь “Орон нутгийн сан”-г шинээр нэмж, 1,000.0 сая төгрөгийн төсөв батлахад голлон нөлөөлжээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах, түүнд хяналт тавих” журмыг “сангийн зориулалт нь өөр сангуудын үйл ажиллагаатай давхардсан” гэсэн шалтгаанаар захиргааны хэм хэмжээний актад бүртгээгүй тул батлагдсан 1,000.0 сая төсвийг хасах шаардлага үүссэн байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/464 дугаар захирамжаар “Төсвийн зохицуулалт хийх тухай” төсвийн шууд захирагчдын төсөв хооронд зохицуулалт хийжээ.

Орон нутгийн тодотгосон төсөв, зохицуулалт хийсэн төсвийг хүснэгтээр харууллаа.



Зарцуулах эрх	Тодотгол	Зохицуулалт	Зөрүү
	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022.05.26 №27	ЗД-ын 2022.12.01 А/464	
ОНТБ	16,328.9	15,463.4	-865.5
ОНХС /сумд/	3,952.0	3,952.0	0.0
Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	6,551.5	6,571.5	20.0
Нийт дүн	26,832.3	25,986.8	-845.5

Аймгийн Засаг дарга нь төсөвтөө зохицуулалт хийхдээ нийт батлагдсан төсвийг 845.5 сая төгрөгөөр бууруулан зохицуулалт хийжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3⁵, 65 дугаар зүйлийн 65.1.1⁶-т тус тус заасныг зөрчсөн тул аудитаар албан шаардлага хүргүүлээ.

Дээрх зохицуулалтаас харахад дийлэнх өөрчлөлт нь “Орон нутгийн сан”-гийн төсвийг хасаж, техник хяналтын сангийн төвлөрүүлэх орлогыг нэмсэн байна.


Эрх бүхий байгууллагын баталсан төсвийг бууруулан зохицуулалт хийсэн нь Төсвийн тухай хуулийг зөрчих, төсвийн хяналт алдагдах үр дагавартай байна.

Иймд төсвийг батлахдаа эрх зүйн үндэслэлгүй санг шинээр нэмж батлахгүй байх шаардлагатай байна.

2.1.2 Хөрөнгийн зардалд төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд нь аймаг хөгжүүлэх үрт болон дүнд хугацааны хөгжлийн бодлоготой үялдаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт

Тайлант онд ОНХС-гийн хөрөнгийг дараах байдлаар баталсан байна.



⁵ /урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх/

⁶ Тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах/



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-г дараах хөрөнгө оруулалтад зарцуулахаар баталсан байна. Үүнд:

- Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд 708.1 сая;
- Барилга угсралт, их засварт 2,238.0 сая;
- Тоног төхөөрөмжид 205.9 сая;
- Төсөл хөтөлбөр арга хэмжээнд 1,072.7 сая;

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтыг 1,557.6 сая төгрөгөөр баталсныг 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж 2,216.4 сая төгрөг болгон 638.8 сая төгрөгөөр өсгөн баталсан байна. Үүнийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №18 /сая төгрөгөөр/

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол		Зөрүү
		2021.12.03 №21	2022.05.26 №27	
1	Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ	135.0	135.0	0.0
2	Тоног төхөөрөмж	79.4	278.6	199.2
3	Их засвар	806.4	927.4	121.0
4	Төсөл хөтөлбөр арга хэмжээ	536.8	875.4	338.6
	Нийт дүн	1,557.6	2,216.4	658.8

Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор аймгийн ОНХО-г дараах хөрөнгө оруулалтад зарцуулахаар баталсан байна. Үүнд:

- Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд 135.0 сая төгрөг;
- Тоног төхөөрөмжид 278.6 сая төгрөг;
- Их засварт 927.4 сая төгрөг;
- Төсөл хөтөлбөр арга хэмжээнд 875.4 сая төгрөг;

Хүснэгтээс харахад орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 875.4 сая төгрөг буюу 39.5 хувийг төсөл арга хэмжээнд, үүнээс 329.0 сая төгрөг буюу 37.6 хувь нь аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, тэмцээн уралдаан, “наадам” эвент арга хэмжээ зохион байгуулах зэрэг хөрөнгийн бус нэг удаагийн шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁷-д заасныг зөрчсөн байна. Төлөвлөсөн төсөл, хөтөлбөр арга хэмжээний урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байдлыг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №19 /сая төгрөгөөр/

ОНХО-ын бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	Нийцсэн			Нийцээгүй		
	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн	Хувь
"Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"	30	1,243.2	56.1	11	973.2	43.9

⁷ "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

"Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"	24	1,090.8	49.2	17	1,125.6	50.8
Алсын хараа 2050 монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	18	1,064.6	48.0	23	1,151.8	52.0

Нийт төлөвлөсөн төсөл арга хэмжээний 43.9 хувь нь "Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-тэй, 50.8 хувь нь "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй, 52.0 хувь нь Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой тус тус уялдаагүй байна. Энэ нь "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах тайлагнах журам"-ын 3.1.4⁸-д заасныг зөрчсөн тул "Орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөвлөмж хүргүүлжээ.

2.2 Төсвийн гүйцэтгэл 80.6 хувьтай, яамдтай байгуулсан гэрээ 92.9 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн нь төсвийн үр ашиг хангалттай байгааг харуулж байна.

2.2.1 Зарим сүмд эргэж төлөгдөх төлбөрийн хассан зээл олгоогүй байгаа нь төсвийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Тус онд төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг 40,864.9 сая төгрөгөөр төлөвлөж, 32,957.1 сая төгрөг буюу 80.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Хүснэгт №13 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Бараа, ажил үйлчилгээний зардал	21,452.8	19,730.5	1,722.3	92.0
Татаас ба урсгал шилжүүлэг	1,091.1	1,013.9	77.2	92.9
Хөрөнгийн зардал	15,535.5	11,103.4	4,432.1	71.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,785.5	1,109.3	1,676.2	39.8
Нийт дүн	40,864.9	32,957.1	7,907.7	80.6

Төсвийн гүйцэтгэлийн зардлыг зардлын бүлгийн дүнгээр авч үзэхэд нийт зардлын 59.9 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 3.1 хувийг татаас, урсгал шилжүүлэг, 33.7 хувийг хөрөнгийн зардал, 3.3 хувийг эргэж төлөгдөх төлбөрийн хассан зээлийн зардал тус тус эзэлж байна.

Төлөвлөгөө, гүйцэтгэлийг зардлын зүйлээр харьцуулахад дараах зардлууд гүйцэтгэл багатай байна. Үүнд:

⁸ /Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах зарчмыг баримталж холбогдох тайлан материалыг хавсарна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;
- Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал;
- Хэрэгцээ шаардлага үндэслэл;
- Мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- Төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;
- Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл



Бараа, ажил үйлчилгээний зардал

Сумдын тусгай зориулалтын сангуудын зардлын төлөвлөгөөг бараа үйлчилгээний бусад зардлын зүйл дээр төлөвлөж, зарцуулдаг ба тайлант онд бараа үйлчилгээний зардлыг 1,321.7 сая төгрөгөөр дугуу зарцуулсан байна.

Төсвийн шинэчлэлтэй холбоотой боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөө, гүйцэтгэлийг тайлагнаж байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл

Хүснэгт №14 /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
➤ Дэлгэрцогт, Дэрэн, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгоогүй	1 Дундговь шууд	66.7	18.6	48.1
	2 Дэлгэрцогт	78.5	0.0	78.5
	3 Дэрэн	164.0	0.0	164.0
	4 Говь-Угтаал	174.4	0.0	174.4
	5 Цагаандэлгэр	154.2	0.0	154.2
	6 Баянжаргалан	83.0	0.0	83.0
	7 Өндөршил	99.0	72.1	26.9
	8 Гурвансайхан	159.3	100.0	59.3
	9 Өлзийт	173.5	50.4	123.1
	10 Хулд	147.5	79.0	68.5
	11 Луус	160.4	110.0	50.4
	12 Дэлгэрхангай	189.7	0.0	189.7
	13 Сайхан овоо	138.0	92.3	45.7
	14 Эрдэнэдалай	239.0	0.0	239.0
	15 Сайнцагаан	660.0	515.0	145.0
	16 Адаацаг	98.3	72.0	26.3
	Нийт дүн	2,785.5	1,109.3	1,676.2
➤ Өмнөх жилүүдэд олгосон зээлийн хугацаа хэтрэлттэй авлагыг барагдуулаагүйтэй тус тус холбоотой байна.				

Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3-т /Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах/ заасны дагуу Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 45 дугаар тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг 56,387.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №15 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл		Зөрүү
	2021	2022	
Бараа, ажил үйлчилгээний зардал	45,907.7	19,730.5	(26,177.2)
Татаас ба урсгал шилжүүлэг	1,824.9	1,013.9	(811.0)
Хөрөнгийн зардал	7,803.6	11,103.4	3,299.8
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	851.6	1,109.3	257.7
Нийт дүн	56,387.8	32,957.1	(23,430.7)

Өмнөх онтой харьцуулахад төсвийн гүйцэтгэл 23,430.7 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт хасагдсантай холбоотой байна. Харин зардлын нэр төрлөөр авч үзвэл хөрөнгийн зардал 3,299.8 сая төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл 257.7 сая төгрөгөөр өссөн байна.



Хөрөнгийн зардлын өсөлт нь улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг өмнөх оноос 1,180.6 сая төгрөгөөр өссөн мөн хөрөнгийн зардлын төлөвлөгөөг 3,289.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Өмнөх аудитаар Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлж байсан зөрчлийг илрүүлж, 2022 оноос эхлэн сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг талбайн хэмжигдэхүүнээр тооцож, дулааны эрчим хүч үйлдвэрлэгч байгууллагатай халаалтын гэрээг шинэчлэн хийж, төсвийг хэмнэлттэй зарцуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

Албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажиллавал сард 34.3 сая төгрөг, жилдээ 240.1 сая төгрөгийг хэмнэх боломжтой байна. Иймд мэргэжлийн байгууллагаар сургуулийн дотуур байрны халаалтын талбайг хэмжүүлэн баталгаажуулж, аймгийн хэмжээнд нэгдсэн бодлогоор оны эхнээс албан шаардлагын хэрэгжилтийг хангуулан ажиллах шаардлагатай байна.

Мөн 2022 оноос өмнө гарсан Эрчим хүчний зохицуулах хороо болон зөвлөлийн тогтоолууд нь тухайн жилийн дундуур халаалтын үнэ тарифт өөрчлөлт оруулсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6.2.5.-д */төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх/* заалттай зөрчилдөн төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудын хооронд гэрээг шинэчлэн хийхэд хүндрэл үүсгэж байна.

Иймд аймгийн Засаг даргаас Эрчим хүчний зохицуулах хороонд дээрх асуудалтай холбоотой зөрчлийг танилцуулж, “Ган илч” ХХК-ны дулааны үнэ тарифыг жилийн дундуур өөрчлөлт оруулбал дараа оны эхнээс мөрдөх талаар уламжлан, асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн гүйцэтгэл

Аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар ОНХС-гийн зардлын төлөвлөгөөг 13,496.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 9,901.2 сая төгрөгийг зарцуулсан байна.


Хүснэгт №17 /сая төгрөгөөр/

№	Сумын нэрс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Дэлгэрцогт	182.4	161.6	20.8
2	Дэрэн	323.8	147.0	176.8
3	Говь-Угтаал	298.4	211.9	86.6
4	Цагаандэлгэр	303.8	146.0	157.8
5	Баянжаргалан	1,051.4	699.7	351.7
6	Өндөршил	537.5	379.2	158.3
7	Гурвансайхан	603.3	208.4	394.9
8	Өлзийт	965.1	486.5	478.7
9	Хулд	354.7	233.5	121.2
10	Луус	483.3	286.3	197.0
11	Дэлгэрхангай	557.5	327.2	230.3

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


12	Сайхан-Овоо	406.6	278.8	127.8
13	Эрдэнэдалай	850.0	428.8	421.2
14	Сайнцагаан	809.8	762.7	47.1
15	Адаацаг	373.4	173.5	199.9
16	Дундговь	4,224.8	3,097.4	1,127.4
17	Хот тохижуулах	994.4	892.0	102.4
18	Засаг дарга	175.9	170.8	5.1
Дүн		13,496.2	9,091.2	4,405.0

Нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодруулахад:



- Улсын төсвөөс ОНХС-д олгох шилжүүлэг 7,875.3 сая төгрөгийг 100 хувь;
- Орон нутгийн татварын орлого 1,435.1 сая төгрөгийг 100 хувь;
- Сангийн эхний үлдэгдэл 4,185.7 сая төгрөгөөс 101.2 хувийг, нийт 13,545.7 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсөв захирагчаар нь тодруулахад:



Нийт зардлын төлөвлөгөөний 60.0 хувийг сумдын ОНХС, 31.3 хувийг аймгийн ОНХС, 7.4 хувийг хот тохижуулах, 1.3 хувийг Засаг дарга сан эзэлж байна. ОНХС-ийн зардлын гүйцэтгэл 9,091.2 сая төгрөг буюу 67.4 хувьтай байна. Энэ нь аймаг, сумдын ОНХС-гийн гүйцэтгэлтэй холбоотой байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл



Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр нийт 2,042.0 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Үүнээс гүйцэтгэлээр тайлант онд 1,948.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 95.4 хувьтай, 93.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Худалдан авах ажиллагааны төрөл	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Гүйцэтгэлээрх үнэ	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь
1	Тендер зарлаж гүйцэтгүүлсэн төсөл арга хэмжээ	1,099.3	1,018.6	926.7	91.0%
2	Шууд гэрээ байгуулж	1,117.1	1,023.4	1,021.9	99.8%



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

гүйцэтгүүлсэн төсөл арга хэмжээ				
дүн	2,216.4	2,042.0	1,948.6	95.4%

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд зохион байгуулсан тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр нийт 1,018.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоос тайлант онд 926.7 сая төгрөгийг олгосон 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд нийт 14 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд тендер шалгаруулалт зохион байгуулахаас 3 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулалтын арга, 10 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд харьцуулалтын арга хэрэглэж тендерийн 92.9 хувь нь амжилттай болсон, 1 төсөл арга хэмжээний тендерийг 3 удаа зарлан, амжилтгүй болж дараа онд шилжсэн байна.

2.2.2 Засгийн газрын яамдтай байгуулсан гэрээг 92.9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн нь санаачлагатай сайн ажилласан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 19 гэрээний 881 заалт арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт №20

№	Гэрээ байгуулсан сайд	Арга хэмжээний тоо	Биелэлтийн дундаж хувь
1	Монгол улсын Шадар сайд	39	95.7
2	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд	21	93.8
3	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	26	98.2
4	Боловсрол шинжлэх ухааны яам	100	93.0
5	Эрчим хүчний яам	14	90.0
6	Барилга хот байгуулалтын яам	101	98.1
7	Эрүүл мэндийн яам	91	84.4
8	Зам тээврийн хөгжлийн яам	29	81.5
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	48	90.9
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	128	88.4
11	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	60	97.3
12	Сангийн яам	45	99.3
13	Хууль зүй дотоод хэргийн яам	38	90.8
14	Соёлын яам	65	90.3
15	Батлан хамгаалах яам	31	90.9
16	гадаад харилцаа	10	90.0
17	Эдийн засаг, хөгжлийн сайд	9	93.3
18	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	18	99.4
19	Батламж /Ерөнхий сайдтай байгуулсан/	7	99.0
	Нийт үнэлгээ	881	92.9

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс гэрээний 2022 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргаж, арга хэмжээ болон зорилтын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж 92.9 хувьтай үнэлэн Засаг даргаар баталгаажуулан, холбогдох яамдад хүргүүлсэн байна.



2.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 288.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Монгол Улсын Их Хурлаас “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталжээ. Тус хуулийн хэрэгжилтэд Төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахаар зохицуулсан. Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г баталсан. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх зааврыг баталсны дагуу төсөв захирагч нарын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит хийх явцад хэрэгжүүлэн ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хэмжээнд тус хуулийг сурталчлан таниулах, хэрэгжүүлэхтэй холбоотой аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Засаг даргын харьяа хэлтэс, агентлагийн төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад танхимаар 4 удаа цахимаар 5 удаа сургалт мэдээлэл хийж давхардсан тоогоор 861 албан хаагч хамруулсан байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалттай холбоотой асуудал

Төсөв захирагчдын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага бүрд хамааралтай 29-35 горим сорилыг хэрэгжүүлэн, илэрсэн зөрчлийг шалтгаан, нөхцөл байдалтай уялдуулан, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх зааврын дагуу шийдлийг гаргаж ажилласан. Аудитаар нийт 288.7 сая төгрөгийн 41 алдаа, зөрчил илэрсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчлийн нэгтгэлийг хавсралт 3-т харуулав.

Илэрсэн алдаа, зөрчлийн хуулийн заалт, шийдвэрлэлтийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт №16 /сая төгрөгөөр/

Хуулийн заалт	Төлбөрийн акт	Албан шаардлага	Залруулга	Дүн
12.1.1 ⁹	1	0.5	-	1 0.5
15.1.3 ¹⁰	15	17.7	-	15 17.7
15.1.5 ¹¹	2	4.1	2 18.6	4 22.7
15.1.6 ¹²	1	1.6	1 10.5	2 12.1
15.1.7 ¹³	1	1.7	-	1 1.7

⁹ 12.1.1-д /гар утасны зардал/

¹⁰ 15.1.3.-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;/

¹¹ 15.1.5-т /Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах/

¹² 15.1.6-д /нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх/

¹³ 15.1.7. /байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно/



15.2.3 ¹⁴		-	1	16.1		1	16.1
15.2.4 ¹⁵		-	1	8.7		1	8.7
4.2.6 ¹⁶	1	0.7	4	61.0	8	134.0	195.7
6.1 ¹⁷	1	0.1		-		1	0.1
6.2 ¹⁸		-	1	2.6		1	2.6
8.1 ¹⁹		-	1	10.8		1	10.8
Нийт дүн	22	26.4	11	128.3	8	134.0	288.7

Нийт алдаа, зөрчлийн шийдвэрлэлтийг авч үзвэл 9.1 хувь нь төлбөрийн акт, 44.5 хувь нь албан шаардлага, 46.4 хувь нь залруулсан алдаа байна.

2. Төрийн хэмнэлтийн бодлогын талаар төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг тайлагнах

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дугаар заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дугаар заалтуудыг зөрчсөн дараах нийтлэг илэрсэн алдаа, зөрчлүүд байна. Үүнд:

- 2022 онд Дундговь аймгийн түүхт 80 жилийн ой тохиож, ойн арга хэмжээний хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-д заасныг зөрчиж, 195.7 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрснээс 134.0 сая төгрөгийн зөрчлийг тухайн шатны төсөвт буцаан төвлөрүүлэхээр санхүүгийн тайланд авлагаар тайлагнуулж залруулан, 61.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.
- Төсвийн захирагчдад хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс давхардуулан урамшуулал олгосон;
- Төсвийн хөрөнгөөр бэлэг, дурсгалын зүйл бэлтгэж, хүндэтгэлийн үйл ажиллагаанд зарцуулсан;

¹⁴ 15.2.3-т /Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх/

¹⁵ 15.2.4-т /бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх;/

¹⁶ 4.2.6-д /үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх/

¹⁷ 6.1-д /Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно./

¹⁸ 6.2-т /Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно./

¹⁹ 8.1. /Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно./

2.4 Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.

2.3.1 Нэмэлт төсвийн дансанд Төсвийн тухай хүүлийн дагуу 3,525.1 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 3,460.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, эхний үлдэгдлээс санхүүжих 64,7 сая төгрөг, нийт 3,525.1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 3,271.0 сая төгрөгийг зарцуулан, 189.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 64.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн хавсралт 2-т харуулав.

Нэмэлт төсвийн эх үүсвэр



Нэмэлт төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг диаграммаар харуулбал нийт орлогын 29.0 хувийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 22.0 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 49.0 хувийг орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого тус тус эзэлж байна.

Тайлант оны нэмэлт төсвийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 2,446.9 сая төгрөгөөр буурсан боловч орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

		Хүснэгт №21 /сая төгрөгөөр/		
№	Нэмэлт төсвийн эх үүсвэр	2021	2022	Өсөлт/ Бууралт
1	Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	431.6	1,690.0	1,235.6
2	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,523.00	993.8	-1,673.8
3	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	720.2	776.7	223.8
4	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	2,232.5	-	-2,232.5
	Нийт дүн	5,907.3	3460.4	-2,446.9

Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж

Тус онд төсвийн ерөнхийлөн захирагч 1,690.0 сая төгрөг буюу өмнөх оноос 3.9 дахин их хандив, тусламжийг авч бүртгэл тайланд тусгажээ. Үүнийг байгууллагуудаар харуулбал:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар 1,455.0 сая төгрөг,
- Сумдын Засаг даргын Тамгын газар 235.0 сая төгрөгийн хандив, тусламжийг тус тус авсан байна.

Хандивын орлого өмнөх оноос 3.9 дахин их, 1,235.6 сая төгрөгөөр өссөн нь тус онд аймаг байгуулагдсаны түүх 80 жилийн ой тохиож, ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас өгсөн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч, тайлагнасантай холбоотой байна.

Мөн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар олон улсын байгууллагаас 50.0 сая төгрөгийн хандив тусламжийг авч, бүртгэл тайланд тусгасан байна. Тус олон улсын байгууллага нь /Ups Renewables Mongolia LLC/ тус сумын нутагт салхин сэнсний төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд нийгмийн хариуцлагын хүрээнд тус хандив, тусламжийг үзүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө

Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 993.8 сая төгрөг төвлөрүүлснийг эх үүсвэрээр нь харууллаа. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлаас 160.0 сая төгрөг,
- Яамдаас 41.3 сая төгрөг,
- Төсөвт байгууллагуудаас 307.9 сая төгрөг,
- Төсөл хөтөлбөрөөс 484.6 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Өмнөх оноос 1,529.2 сая төгрөгөөр буурсан нь 2021 онд Эрүүл мэндийн төвүүд Коронавируст цар тахалтай холбоотой хэвтэн эмчлүүлсэн болон төлбөртэй үйлчилгээ үзүүлсний төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилж, 2,232.5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч тайлагнасан холбоотой байна.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 204.5 сая төгрөг, тухайн жилийн давсан орлого, хэмнэгдсэн зардал 38.4 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих 533.8 сая төгрөг, нийт 776.7 сая төгрөгийг эрх нээлгэн зарцуулжээ. Дээрх орлогууд нь өмнөх оноос 56.2 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна.

2.3.2 Нэмэлт төсвийг эрх нээлгэн зарцуулснаас 70 хувийг бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулжээ.



Нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн зардалд 3,525.2 сая төгрөгийг тайлагнаснаас бараа, ажил үйлчилгээний зардалд 2,468.9 сая төгрөг, татаас, урсгал шилжүүлэгт 296.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 759.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнийг диаграммаар харууллаа.



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бараа, ажил үйлчилгээний зардал нийт зардлын 70.0 хувийг эзэлж байгаа нь бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалттай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад өмнөх оноос 2,317.3 сая төгрөгөөр буурчээ.

Хүснэгт №22 /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021	2022	Өсөлт/ бууралт
1	Бараа, ажил үйлчилгээний зардал	3,978.2	2,468.9	(1,509.3)
2	Татаас, урсгал шилжүүлэг	1,314.1	296.6	(1,017.5)
3	Хөрөнгийн зардал	550.2	759.7	209.5
Нийт дүн		5,842.5	3,525.2	(2,317.3)

Нийт зардал өмнөх оноос буурсан нь өмнөх онд Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа үйлчилгээний бусад зардал их байсантай холбоотой байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн орлогыг 40,864.9 сая төгрөгөөр төлөвлөж, 108.5 хувийн гүйцэтгэлтэй, 3,490.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч Гурвансайхан, Сайхан-Овоо, Луус сумд орлогын төлөвлөгөөг 0.3-2.9 хувиар тасалжээ. Мөн татварын орлогыг нэр төрлөөр авч үзэхэд үйл ажиллагааны орлого, малын тоо толгойн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, үл хөдлөх эд хөрөнгийн татварын орлогууд тасарчээ.
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос орон нутгийн төсөвт гүйцэтгэлээр 72.7 сая төгрөгийг хуваарилж, орлогын төлөвлөгөө 302.0 сая төгрөгөөр тасарчээ.
3. Төсвийн тухай хуулийг зөрчин тодотгосон төсвийг Засаг даргын захирамжаар 845.5 сая төгрөгөөр бууруулан зохицуулалт хийсэн байна.
4. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах, түүнд хяналт тавих” журмыг захиргааны хэм хэмжээний актад бүртгээгүй байхад сангийн орлого, зардлыг баталсан байна.
5. Өмнөх оны аудитаар боловсролын байгууллагуудын тогтмол зардалтай холбоотой зөрчилд өгсөн албан шаардлага бүрэн хэрэгжээгүй, одоог хүртэл дотуур байрны халах талбайн хэмжээ маргаантай мөн халаалтын үнэ тарифыг төсвийн жилийн дундуур нэмдэг асуудлууд илэрсээр байна.
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 288.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.
7. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 41.5 хувиар буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.
8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хандив, тусламжийн орлого өмнөх оноос 3.9 дахин өссөн нь тус онд аймаг байгуулагдсаны түүх 80 жилийн ой тохиож, ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас өгсөн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч, тайлагнасан байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

- Орон нутгийн төсвийг батлуулахдаа хууль, эрх зүйн үндэслэлтэй орлого, зардлыг төлөвлөх;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн, төсвийг хэмнэлттэй, хяналттай зарцуулах;
- Мэргэжлийн байгууллагаар сургуулийн дотуур байрны халаалтын талбайг хэмжүүлэн баталгаажуулж, дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээнд хяналт тавьж ажиллах;

Аймгийн Татварын хэлтэст:

- Тасарсан татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэхэд анхаарч, тасарсан шалтгааныг тодруулан дүн шинжилгээ хийх;
- Тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан орлогыг бодитой төлөвлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах;
- Орон тоо сул сумдыг байцаагчтай болгож хүний нөөцийг бүрэн бүрдүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах;



ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна.

Нөхцөл байдал 1:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүсэлтээр Сангийн яамнаас 2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын урьдчилж орсон орлого 303.3 сая төгрөгийг аймгийн Төрийн сангийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дансанд олгожээ.

Дээрх шилжүүлгийг Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Санхүүгийн тайланд урьдчилж орсон орлогоор бүртгэсэн боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Энэ нь тайлант онд хамааралгүй, 2023 оны орлогоос урьдчилж орсон орлогыг татварын орлогын гүйцэтгэлээр тайлагнаж, тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах эрсдэлтэй байна.

Тус орлогыг 2023 оны санхүүгийн дэмжлэг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувиас суутган шилжүүлэх эсэх тодорхойгүй, аймгийн 2023 оны төсвийн эх үүсвэрт 303.3 сая төгрөгийн буцаан төвлөрүүлэх асуудал тусгагдаагүй байна.

Мөн аймагт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төлөвлөгөөг 374.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь бодит гүйцэтгэлээс 302.0 сая төгрөгөөр их, төлөвлөгөө, гүйцэтгэлийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна.

Санал:

Сангийн сайдын 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангаж, төлөвлөлт, төвлөрүүлэлтийн систем тодорхой байх, аймагт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлөвлөгөөг бодитой төлөвлөх талаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлэх саналтай байна.



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР


Дундговь аймгийн засаг даргаас ирүүлсэн санал, тайлбар


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын ордон,
7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn
Т. Оюун - 7/20/22
Самсрын тусламж
аудит
Детал төлөвлөгөө
14/20
dddb . 24.20 № 01/340
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн
захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн аудит
хийсэн тайланд санал байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4803140361

Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаас ирүүлсэн санал, тайлбар:


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
С.Баяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: (976) 70592494 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn
2022. 04. 20 № 06/549
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Г.Оюун - Эрдэнэ
Сүлдэн хариу өсөл.
14/20

Тайлбар хүргүүлэх тухай.

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтын дагуу “Орон нутгийн санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах түүнд хяналт тавих” журмыг боловсруулан Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, сангийн орлого, зарлагын хамт аймгийн төсөвт тусган батлуулсан. Гэвч Хууль зүйн, дотоод хэргийн яам захиргаааны хэм хэмжээний актад бүртгээгүй тул орон нутгийн сангийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болж орлого, зарлагыг Аймгийн засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилгоор Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 42 дугаар зүйлийн 42.2.1 (г) дэх заалтын дагуу төсөв хооронд зохицуулалт хийсэн болно. Ингэснээр батлагдсан төсвийг хэтрүүлээгүй бөгөөд хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд төсөв хоорондын зохицуулалтыг хийсэн.

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.ЭНХТАЙВАН

Тайлбар:

Төсөвт зохицуулалт хийсэн Засаг даргын захирамж нь ИТХ-ын баталсан төсвийн орлого, зарлагыг нийт 845.5 сая төгрөгөөр бууруулж Төсвийн тухай хуулийн 6.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1-т тус тус заасныг зөрчсөн тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.



ХАВСРАЛТ

Хавсралт №1

НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,864,902,600.00	32,957,164,833.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,543,915,800.00	20,744,429,239.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,452,822,900.00	19,730,512,012.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,821,079,500.00	6,632,802,867.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	860,248,600.00	809,932,528.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,415,656,600.00	5,343,440,098.29
2104	Хангамж, бараа материалын зардал	620,877,900.00	599,559,887.03
2105	Нормативт зардал	95,143,100.00	86,340,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	713,878,400.00	689,545,259.00
2107	Томилолт, зочны зардал	197,062,300.00	190,450,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,608,074,800.00	1,579,301,833.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,120,801,700.00	3,799,138,258.94
212	ТАТААС	122,000,000.00	112,000,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	80,000,000.00	70,000,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	42,000,000.00	42,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	969,092,900.00	901,917,227.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	969,092,900.00	901,917,227.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,535,533,700.00	11,103,421,737.50
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,785,453,100.00	1,109,313,856.32
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,864,902,600.00	33,330,376,261.19
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,875,341,600.00	7,875,341,556.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,164,825,000.00	23,080,666,297.05
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,824,736,000.00	2,374,368,408.14
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	7,525,958,718.35
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	7,597,400,902.12

Хавсралт №2

НЭГТГЭСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,525,170,573.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,765,462,699.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,468,861,709.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,896,057.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,280,593.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,932,044.84



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2104	Хангамж, бараа материалын зардал	85,876,772.60
2105	Нормативт зардал	140,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,668,339.16
2107	Томилолт, зочны зардал	41,409,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,655,417.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,932,003,035.29
212	ТАТААС	8,049.40
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	8,049.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	296,592,940.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,501,670.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	254,091,270.26
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	759,707,874.00
2200	Дотоод эх үүсвэрээр	759,707,874.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,460,434,995.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,460,434,995.31
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-64,735,578.08
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	64,745,168.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,590.08

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн утга	Шийдвэрлэсэн байдал	/мянган төгрөг/	
				Нийт алдаа зөрчил	
				Тоо	Дүн
1	Өлзийт сумын ЗДТГ	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	437.6
2	Хулд сумын ЗДТГ	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	832.9
3	Адаацаг сумын ЗДТГ	Аудитаар байгууллагын төсвөөс иргэн, төрийн бус байгууллагад хандив, тусламж олгосон.	Албан шаардлага	1	1,000.0
		Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд түүхийн ном бүтээх ажлын зардлыг төсвөөс шилжүүлж, үндсэн чиг үүрэгт хамааралгүй, дунд хугацааны бодлогот тусгагдаагүй зардалд зарцуулсан	Албан шаардлага	1	20,000.0
4	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	1,670.9
		АИТХ-ын нарийн бичгийн дарга нь аймаг дотор албан тушаалын суудлын автомашин ашиглаж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг зөрчсөн.	Төлбөрийн акт	1	107.9
		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалтыг зөрчиж, тээвэр шатахууны зардлыг хяналтгүй, хэмнэлтгүй зарцуулсан.	Албан шаардлага	1	2,569.3
5	Сайхан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Аудитаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт бичиг хэрэг, шатахууны зардлыг олгохдоо бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн төсвийг зарцуулсан	Албан шаардлага	1	10,499.8
6	Адаацаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Аудитаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт бичиг хэрэг, шатахууны зардлыг олгохдоо бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэсэн.	Албан шаардлага	1	8,740.0
7	Сайнцагаан сумын Хоршоо хөгжүүлэх сан	Хоршоо хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулах хороо болон хяналтын зөвлөлийн гишүүдэд нэгж олгосон	Төлбөрийн акт	1	500.0
8	Сайнцагаан ЗДТГ Дундговь аймгийн ЗДТГ	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс балансын урамшуулал олгосон	Төлбөрийн акт	1	832.9
		Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	887.1
		Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авсан.	Төлбөрийн акт	1	1,679.1
		Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ажилчдад биеийн тамирын хувцас худалдаж авсан.	Албан шаардлага	1	10,826.5
9	Говь-Угтаал сумын ЗДТГ	Төсвийн ерөнхийлөн захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	838.1
10	Дэлгэрцогт сумын ЗДТГ	Төсвийн ерөнхийлөн захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	838.1
11	Дэрэн сумын ЗДТГ	Төсвийн захирагч нарт хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс балансын урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	1,666.3
		Дундговь аймгийн 80 жилийн ойн нээлт, хаалтын үйл ажиллагаанд төсвөөс шилжүүлж, үндсэн чиг үүрэгт хамааралгүй зардалд зарцуулсан.	Албан шаардлага	1	20,000.0
12	Өндөршил сумын ЗДТГ	Төсвийн захирагч нарт хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс балансын урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	1,525.3
13	Баянжаргалан сумын ЗДТГ	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс балансын урамшуулал олгосон	Төлбөрийн акт	1	838.1
14	Цагаандэлгэр сумын ЗДТГ	Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд түүхийн ном бүтээх ажлын зардлыг төсвөөс шилжүүлж, үндсэн чиг үүрэгт хамааралгүй, дунд хугацааны бодлогот тусгагдаагүй зардалд зарцуулсан	Албан шаардлага	1	20,000.0
15	Дэлгэрхангай сумын ЗДТГ	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	1,670.9
		Төсвийн хөрөнгөөр сумын хэсгийн төлөөлөгчийг шилжихэд хүндэтгэл үзүүлсэн	Төлбөрийн акт	1	741.0
16	Луус сумын ЗДТГ	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	832.9
17	Сайхан-овоо сумын ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр бэлэг, дурсгалын зүйл бэлдэж, хүндэтгэл үзүүлэн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн.	Төлбөрийн акт	1	600.0
		Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	1,670.9
18	Эрдэнэдалай сумын ЗДТГ	Төсвийн хөрөнгөөр шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн.	Төлбөрийн акт	1	1,600.0

		Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин төрийн чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагаанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн.	Албан шаардлага	1	2,926.0
		Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан.	Албан шаардлага	1	15,633.8
		Тээвэр шатахууны батлагдсан төсвийг 2.6 дахин хэтрүүлэн, өглөг үүсгэн төсвийг хэмнэлтгүй зарцуулсан.	Албан шаардлага	1	16,107.9
		Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвийн хөрөнгөөр бэлэг, дурсгалын зүйл бэлтгэж, хүндэтгэлийн үйл ажиллагаанд зарцуулсан	Төлбөрийн акт	1	3,500.0
		Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, хамааралгүй хууль, эрх зүйг үндэслэн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан бусад урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	1,670.9
19	Гурвансайхан сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	20,000.0
20	Дэлгэрхангай сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	20,000.0
21	Дэлгэрцогт сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	10,000.0
22	Өндөршил сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	19,882.4
23	Сайхан-Овоо сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	5,000.0
	Сайнцагаан сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	19,800.0
24	Хулд сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	19,293.9
25	Эрдэнэдалай сумын ОНХС	Сумын ОНХС-гийн хөрөнгийг иргэдээс санал аваагүй, сумын дунд хугацааны бодлогод тусгаагүй Дундговь аймгийн 80 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан.	Залруулга	1	20,000.0
26	Дундговь-Ус ОНӨААТҮГ	Байгууллагын удирдлагад үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон.	Төлбөрийн акт	1	1,500.0
Нийт дүн				41	288,720.5